

ЯРИЛЦАВ УУ? ЯЛ АСУУВ УУ?

Ч.Чойсамба*

* МУИС, НШУС, Сэтгүүл зүйн тэнхмийн багш, доктор (Ph.D.), МУИС-ийн дэд профессор

Түлхүүр үг: ярилцлага, асуулт, сэдэв, ярилцлагад бэлдэх нь.

«Өдрийн сонин»-ы 2005 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн дугаарт тухайн үеийн Байгаль орчны сайд У.Барсболдтой Ж.Сандагдоржийн хийсэн «Биднээс хамаарах, хамаарахгүй хоёулангаас нь шалтгаалж цөлжилт үүсч байна» гарчигтай хоёр нүүр дамнасан ярилцлага нийтлэгджээ. «Экологийн сэтгүүл зүй» гэдэг гарын авлага бичсэн болохоор ихэд сонирхон уншлаа. Гэвч хэг ёг гэсэн анхны асуултаас эхлээд л хачин сэтгэгдэл төрлөө. Яллаад ярдаглаад, зэмлээд зандраад ч байгаа юм шиг. Хэрүүл гуйсан ч юм шиг, өдөөн хатгасан ч юм шиг. Ийм хачин «ярилцлага» хэвлэлд тэр бүр гардаггүй. Тиймээс сэтгэгдлээ бичихээр шийдлээ.

Ж.Сандагдорж ярилцлагаа «Хүрээлэн буй байгаль орчны асуудлаар манайх үндэсний томоохон хэвлэлийн хувьд маш анхааралтай ханддаггыг та анзаардаг байх?» гэж тун ч хачирхалтай

асуултаар эхэлжээ. Аливаа ХМХ том жижиг, үндэсний орон нутгийн гэлтгүй байгаль орчны асуудалд анхаарал хандуулах үүрэгтэй. Байгаль орчны асуудлыг хөндчихлөө гээд цээжээ дэлдээд, буян үйлдэж буй мэт авирлаад байх хэрэггүй юмсан.

Дараа нь «Хэн нэгнийг муулах, магтах, сонин хачин болгож дэвэргэх талбар бол яавч байгаль орчны сэдэв биш байх» гэсэн боловч асуулт болгоноороо Байгаль орчны сайд У.Барсболдоос ам асууж, тавлаж, яллаж, цэцэрхэж, ярилцлага авч буй сэтгүүлчийн зайлсхийвэл зохих бүх бүдүүлэг аргыг чадамгай хэрэглэсэн аж. Эдгээрийг дэлгэрүүлэн үзье.

Сэтгүүлч ярилцлага авах гэж буй сэдвийнхээ талаар урьдчилж мэдээлэл цуглуулсан байх шаардлагатай гэж сэтгүүл зүйн сурах бичгүүдэд заадаг¹. Ялангуяа байгаль орчин зэрэг нарийн сэдвээр ярилцлага хийх гэж буй бол бэлтгэл бүр ч зайлшгүй. Нарийн мэргэжлийн, тухайлбал экологийн сэдвээр ярилцлага хийхээр төлөвлөсөн сэтгүүл-

чид урьдчилсан бэлтгэл юу юунаас чухлыг Америкийн нэрт экологич-сэтгүүлч Шарон Фридман тэмдэглэсэн байдаг. Гэтэл Ж.Сандагдорж ямар ч бэлтгэлгүйгээр барахгүй үзэл сурталжсан хэдэн асуултаар зэвсэглээд Байгаль орчны сайд У.Барсболдтой уулзжээ. Ж.Сандагдоржид нэг ч тоо, нэг ч баримт, нэг ч тодорхой мэдээлэл алга. *«Таныг эрх барьж буй энэ олон жилийн дотор монгол орны дархан цаазат гэх мэт хамгаалалтанд авсан газар нутаг хэр зэрэг нэмэгдсэн бэ. Эсвэл хасагдсан уу?»* гэсэн асуултаас энэ нь илэрхий харагдаж байна. Энэ асуултад нь У.Барсболд сайд: «Тусгай хамгаалалттай газар нутагт 2000 оноос хойш Тужийн нарс, Мянган угалзатын нуруу, Хөвсгөлийн улаан тайга, Алтан-Овоо, Шилийн богд, Хөгнө хан уул, Элсэн тасархай гээд олон газрыг нэмж авлаа. Харин нэг ч га талбай хасагдаагүй» гэж хариулжээ. Ямар учраас эдгээр газрыг дархан цаазтай болгосон, ингэснээр ямар үр дүн гарсан, ойрын үед өөр ямар газрыг нэмж хамгаалалтад авах тухай асуудал Ж.Сандагдоржид сонирхолгүй санагдсан бололтой, энэ тухай нэг үг ч цухуйлгасангүй.

«

Сэтгүүлч ярилцлага авах гэж буй сэдвийнхээ талаар урьдчилж мэдээлэл цуглуулсан байх шаардлагатай гэж сэтгүүл зүйн сурах бичгүүдэд заадаг. Нарийн мэргэжлийн, тухайлбал экологийн сэдвээр ярилцлага хийхээр төлөвлөсөн сэтгүүлчид урьдчилсан бэлтгэл юу юунаас чухлыг Америкийн нэрт экологич-сэтгүүлч Шарон Фридман тэмдэглэсэн байдаг

»

Ер нь Ж.Сандагдоржид БОЯ-ны үйл ажиллагааны талаарх тоо баримт чухал биш, гагцхүү бүхнийг үгүйсгэх хүсэлдээ хөтлөгдсөн нь дараа дараагийн асуултаас бүр ч тодорхой харагдана. Баримт цуглуулахынхаа оронд Ж.Сандагдорж хов жив, цуу ярианд «найдвар» тавьжээ. *«Яармагийн замаар явдаг олон хүн ... танай яамыг тавалцгаадаг?»*, *«Ямар ч байсан боодогны үнэ тэнгэрт хадаж олдоц муутай дуулдах юм»*, *«Гадуур улс амьтан ярилцах нь Монголын ихэнх нутаг ашигт малтмалын хайгуулын лицензийн талбар болсон гэлцэх юм»*, *«Богд уулын дархан цаазат газраас зөвшөөрөл, газар олголттой холбогдсон хэл ам таны сонорт хүрээ байлгүй»* гэх мэт асуултаас Ж.Сандагдорж юуг «эх сурвалж»-аа болгосон нь андашгүй байна.

Боодог олдоц муутай байгааг шүүмжлээд ч байгаа юм шиг. Тарвага агнахыг хориглосон шийдвэрийг буруутгаад ч байгаа юм шиг. Асуулт болгоны цаана далд санаа хоргодож байна.

БОЯ-ны үйл ажиллагааг бүхэлд нь үгүйсгэсэн өнгө аяс асуултуудаас цухалзаж байна. *«Усны бодлогыг шинэчилнэ гэж их ярьсан. Бодлого амьдрал дээр хэр амжилттай бууж ирж байна даа»*,

«Удахгүй энэ нутаг орон ухсан талбайгаар дүүрэх бололтой?», «...Энэ оронд хүрээлэн буй орчныг хамгаалах асуудал яагаад дорвитой сонсогдохгүй байна?», «Сэлэнгэ мөрөн зэрэг томоохон гол мөрний усыг ашиглаж говийг усжуулах тухай яриа бий. Бүтдэгсэн бол сайхан санаа», «Агаарын бохирдлын тухай яриа жил бүрийн өдийгөөс эхлэн хавар болтол өрнөдөг. Удахгүй энэ сэдвээр хэвлэлүүд ээлжит нэвтрүүлгээ эхлэх биз», «"Ногоон хэрэм"-ийн үр дүн аль вэ» зэрэг асуултаас БОЯ хүрээлэн буй орчныг хамгаалах тал дээр юу ч хийдэггүй, хий хоосон утопи зүйл ярьж байдаг гэсэн ойлголтыг уншигчдад өгч буйгаараа хорлонтой болжээ. МАХН-ын хүн энэ яамыг толгойлж байгаа л учраас бүхэл бүтэн байгууллагын үйл ажиллагааг ингэж үгүйсгэж болох уу? Ер нь Монгол улсад БОЯ ямар ч хэрэггүй мэт. Мөн зарим нэг асуултынхаа логикийг ч бодолцмоор. Хэвлэлүүд нэвтрүүлэг хийдэг юм шиг жигтэй алдааг ХМХ-д ажилладаг хүн гаргасныг юу гэж ойлгох вэ?

У. Барсболд сайдыг ярилцагч гэдгийг Ж.Сандагдорж ор тас мартсан бололтой. Өөрийгөө яллагч, У.Барсболдыг яллагдагч гэж эндүүрсэн юм шиг. «Оюу толгойн уланд байгаа говийн гүний усыг яагаад тэдэнд өгчихөв. Тэнд дээрээ усгүй. Одоо гүн дэх нөөцийг нь барж орхино доо?» гэж ширүүлж, зандарсан байна. Тэдэнд гэж хэнийг хэлэв? Бодвол, Р.Фридландыг юм байлгүй.

«Тарвага агнахыг хорьсон... Дуусчихсан хойно нь хориг тавьсан юм биш биз дээ?» гэж тавласнаас БОЯ хүрээлэн буй орчин, түүний нөөц баялгийг хамгаалах тал дээр ямар ч дорвитой арга хэмжээ авч чаддаггүй, мэддэггүй гэсэн санаа өнгөлзөж байна. Ёстой л өнгөрсөн борооны хойноос цув нөмрөв гэгч зарчмаар БОЯ ажилладаг юм шиг.

«Барсболдын буянаар модны үнэ өслөө гээд хулгайн модчид туйлын баяртай явна. Таньд өөрийн биеэр ирцгээж баяр хүргэв үү?» гэсэн асуулт юун тэр мэргэжлийн ёс зүй, бүр эрээ цээрээ алджээ. У.Барсболд сайд байгаль орчинд халтай, хулгайн модчдод ээлтэй хүн юм шиг. Ухаан нь модны үнэ өссөнөөр хулгайн анчид хагартлаа баяжиж, баярласан хэрээ бархирна гэгчээр Байгаль орчны сайд дээр ирж, талархсанаа илэрхийлэх хэрэг үү? Тэгээд ч хулгайн модчид У.Барсболд сайдад баярлаж явдгийг Ж.Сандагдорж яаж мэдсэн юм бол?..

У.Барсболд сайдыг ч тун эвгүйгээр хэд хэд хатгаад авч. «Ирээдүй хойчоо бодсон ямар үйл хэрэг энэ Засгийн газарт, энэ яаманд өрнөж байгаа тухай үг тань чухал байна?», «Монгол төрийн бодлогоор Байгаль орчны салбарыг тогтвортой, суурьшилтай, ажиллуулахын тулд Засгийн газрууд дамнуулан ганцааранг нь үлдээсэн үү?», «Таныг эрх барьж буй энэ олон жилийн дотор...» гэх мэт асуултад тавласан өнгө аяс сохор хүнд ч харагдахаар байна. БОЯ юу ч хийж гүйгүүлээгүй,

тийм байхад таныг яагаад улираан сонгосон юм гэж асуух гээд арай л асууж зүрхэлсэнгүй бололтой. Мөн У.Барсболдыг олон жил төрийн эрх барьсан гэснийг юу гэж ойлгох вэ?

Олон нийтэд үнэн бодитой мэдээлэл түгээх гэдэг үндсэн үүргээ манай зарим ХМХ-ийн ажилтан ор тас умартаж, үзэл суртлын дайчин болж, бүхнийг хардах хандлагатай болжээ. Цагаан цааснаас хүртэл хар толбо олохыг чармайж, олдохгүй бол зориуд дээрээс нь хар бэх дусаана. «Бурхан багшийн сэрэг дүр амилж нийслэлчүүдийн нүд хужирлах үзмэр нэгээр нэмэгдлээ. Соёл урлагийн байгууламжийг босгоход та ихэд зүтгэсний учир юу вэ?» гэсэн асуулт цаанаа л нэг хардаж сэрдсэн өнгө аястай. Соёл урлагийн байгууламж гэж тодотгосноос үзэхэд Байгаль орчны сайд ийм ажилд оролцож болдоггүй мэт. Ямар но-той учраас бурхан багшийн хөшөөг босгоход ингэглээ ихэд зүтгэсэн юм бэ? гэж асууснаас энэ нь өөрцгүй. У.Барсболд сайд: «Монгол хүний ахуй амьдралд, хүн хүнээ хайрлахад, байгаль дэлхийг хамгаалах, эв найртай байх талаар бурхан багшийн сургаалаас илүүг олоход бэрх. Монгол хүн бүрийг заяаг бодож, монгол түмэн сайн сайхан амьдраасай гэсэндээ монгол хүн бүр очих Бурхан багшийн сэрэг дүрийг бүтээн босголцсон» гэж хариулжээ.

БОЯ байгаль орчноо хамгаалах ажлыг нэр төдий оромддог гэсэн санаа асуултаудад амь бөхтэй оршиж байна. «Ирэх жилийг Байгаль орчны яам

байгаль орчны хувьд юуны жил болгох вэ?» гэсэн асуултаас үүнийг төвөггүй ажиглаж болно. Тодруулбал, аль нэг жилийг ой мод хамгаалах он болгож зарладаг ч ой модоо хамгаалах тал дээр дорвитой зүйл хийдэггүй гэсэн санааг Ж.Сандагдорж илэрхийлжээ.

Муу л бол арын хар овоохой гэгчээр энэ дэлхий дээр болохгүй бүтэхгүй байгаа бүхэн БОЯ, түүний сайдтай холбоотой мэт. «Хүрээлэн буй орчны дулаарал дэлхийн цаг уурын төлөвийн талаар гэрэл гэгээтэй сураг юу байх юм бэ. Удахгүй хойд мөсөн далай хүртэл хайлах нь гэж түгшээх боллоо?» гэж асууснаас үзэхэд байгалийн энэ гамшигт БОЯ буруутай ч юм шиг. Тэгээд ч өмнөт туйл буюу Антарктидын мөс хайлах төлөвтэй гэж ярьж байгаагаас Хойт мөсөн далай хайлна гэсэн яриа гараагүй.

Аливаа яам, засгийн газрын үйл ажиллагаанд шүүмжлэлтэй хандаж болноо. Гэхдээ энэхүү шүүмжлэл нь үндэслэлтэй, ажил хэрэгч байх ёстой. Түүнээс биш сайдыг намаар нь гадуурхаж ялладаг, улмаар бүхэл бүтэн яамны үйл ажиллагааг үгүйсгэдэг ийм нигилист хандлага байж болохгүй. Ажлыг сайжруулъя гэж шүүмжилдгээс хийснийг нь үгүйсгэх гэж шүүмжилдэггүй.

У.Барсболд сайд харин ноён нуруутай хандаж, бүхий л өдөөн хатгасан асуултад нь тодорхой тоо баримттай, жишээтэй хариулсан байна. Алдаа онооныхоо талаар ч нууж хаалгүй илэн далангүй яриа өрнүүлжээ. Өдөөн

хатгасан асуултуудад нухацтай, буурь суурьтай хариулт өгчээ.

Нөгөө талд боломж олго гэж нэг сайхан үг байдаг даа. Тэр боломжийг нөгөө талд олгоё. Ж.Сандагдоржийн тавьсан 18 асуултыг алдаа мадагтай чигээр нь уншигч танд толилуулъя. Энэ асуудлыг та ч гэсэн өөрийн байр сууринаас харж, дүгнэж цэгнэгтүн.

«Хүрээлэн буй байгаль орчны асуудлаар манайх үндэсний томоохон хэвлэлийн хувьд маш анхааралтай ханддаггыг та анзаардаг байх?»

«Хэн нэгнийг муулах, магтах, сонин хачин болгож дэвэргэх талбар бол яавч байгаль орчны сэдэв биш байх. Ирээдүй хойчоо бодсон ямар үйл хэрэг энэ Засгийн газарт, энэ яаманд өрнөж байгаа тухай үг тань чухал байна?»

«Монгол төрийн бодлогоор Байгаль орчны салбарыг тогтвортой, суурьшилтай, ажиллуулахын тулд Засгийн газрууд дамнуулан ганцааранг нь үлдээсэн үү?»

«Усны бодлогыг шинэчилнэ гэж их ярьсан. Бодлого амьдрал дээр хэр ам-жилттай бууж ирж байна даа. Оюу толгойн уланд байгаа говийн гүний усыг яагаад тэдэнд өгчихөв. Тэнд дээрээ усгүй. Одоо гүн дэх нөөцийг нь барж орхино доо?»

«"Ногоон хэрэм"-ийн үр дүн аль өз. Яармагийн замаар явдаг олон хүн хэдэн хатсан бургасыг зааж танай яамыг тавалцгаадаг?»

«Барсболдын буянаар модны үнэ өслөө гээд хулгайн модчид туйлын баяртай явна. Таньд өөрийн биеэр ирцгээж баяр хүргэв үү?»

«Таныг эрх барьж буй энэ олон жилийн дотор монгол орны дархан цаазат гэх мэт хамгаалалтанд авсан газар нутаг хэр зэрэг нэмэгдсэн бэ. Эсвэл хасагдсан уу?»

«Гадуур улс амьтан ярилцах нь Монголын ихэнх нутаг ашигт малтмалын хайгуулын лицензийн талбар болсон гэлцэх юм. Удахгүй энэ нутаг орон ухсан талбайгаар дүүрэх бололтой?»

«Аль ч үеийн Засгийн газрын дэмжлэг авдаг уул уурхайн салбартай болчихсон энэ оронд хүрээлэн буй орчныг хамгаалах асуудал яагаад дорвитой сонсогдохгүй байна?»

«Бурхан багшийн сэрэг дүр амилж нийслэлчүүдийн нүд хужирлах үзмэр нэгээр нэмэгдлээ. Соёл урлагийн байгууламжийг босгоход та ихэд зүтгэсний учир юу өз?»

«Богд уулын дархан цаазат газраас зөвшөөрөл, газар олголттой холбогдсон хэл ам таны сонорт хүрээ байлгүй. Ялангуяа Зайсан толгойн цаагуур хашаажуулсан орчин ямар учиртай хэний хүүгийн мэдлийн нутаг болчихоо өз?»

«Тарвага агнахыг хорьсон. Энэ жил түрүүчийн үр дүн харагдав уу. Ямар ч байсан боодогны үнэ тэнгэрт хадаж олдоц муутай дуулдах юм. Дуусчихсан

хойно нь хориг тавьсан юм биш биз дээ?»

«Та өөрөө анд хэр вэ?»

«Хүрээлэн буй орчны дулаарал дэлхийн цаг уурын төлөвийн талаар гэрэл гэгээтэй сураг юу байх юм бэ. Удахгүй хойд мөсөн далай хүртэл хайлах нь гэж түгшээх боллоо?»

«Сэлэнгэ мөрөн зэрэг томоохон гол мөрний усыг ашиглаж говийг усжуулах тухай яриа бий. Бүтдэгсэн бол сайхан санаа.»

«Ирэх жилийг Байгаль орчны яам байгаль орчны хувьд юуны жил болгох вэ?»

«Агаарын бохирдлын тухай яриа жил бүрийн өдийгөөс эхлэн хавар болтол өрнөдөг. Удахгүй энэ сэдвээр хэвлэлүүд ээлжит нэвтрүүлгээ эхлэх биз.»

«Улаанбаатарт барилга олноор сүндэрлэх нь сайхан ч мод зүлэг хөлд нь үрэгдэж дууслаа. Нийслэлийн удирдлагатай хамаатай асуудал боловч энэ тал дээр танай яам яах ёстой вэ?. Мод цэцэрлэггүй шороо манарсан ийм нийслэл гадаадад аль хэр олон тааралдах юм бэ?»

Ишлэл

¹ Тухайлбал: Менчер М. 2002. Сэтгүүл зүйн бичлэгийн үндэс. УБ., 157 дахь тал.

² Фридман Ш. М., Фридман К. А. 1998. Пособие по экологической журналистике. Taxis, с. 18-19.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. З у л ь к а ф и л ь М. Орчин үеийн сэтгүүл зүй. УБ. 1998.
2. Нийтлэл, нэвтрүүлгийг яаж бэлтгэх вэ? (Орч. М. Зулькафиль.) 2 дахь хэвлэл. УБ. 1998.
3. Н о р о в с ү р э н Л. Сонины бичлэгийн төрөл, зүйл. УБ. 1994.
4. Н о р о в с ү р э н Л. Монголын тогтмол хэвлэлийн бичлэгийн төрөл, зүйл. УБ. 1996.
5. Ч о й с а м б а Ч. 2001. Сонины мэдээллийн бичлэгийн төрөл. УБ.
6. Ч о й с а м б а Ч. 2002. Экологийн сэтгүүл зүй. УБ.
7. А н т о н о в В. И. Информационные жанры газетной публицистики. Саранск. 1996.
8. В о р о ш и л о в В. В. Журналистика. 3-е изд. СПб. 2001.
9. В о с к о б о й н и к о в Я. С., Ю р ь е в В. К. Журналист и информация. М. 1993.
10. Т е р т ы ч н ы й А. А. Жанры периодической печати. М. 2000.
11. Ш о с т а к М. И. Интервью. М. 1997.

Резюме

В данной статье автор подвергает анализу интервью, опубликованное в "Газете дня". Журналист, по мнению автора, возомнил себя не работником СМИ, а инквизитором. В качестве "подсудимого" выступает тогдашний министр природы и окружающей среды Монголии.